



# ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Арвайхээр хот. 2025 оны 4-р сарын 18

### АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аудитын дэд төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

**Аудитын гол дүгнэлт:** ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ ХЭРЭГЖИХ НИЙТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ 57.6 ХУВИЙГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИУДЫН ХОЛБОГДОХ ЗААЛТТАЙ НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

**Тайланг хүргүүлсэн этгээд:** УАГ-ын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар

**Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:** [www.audit.mn](http://www.audit.mn), [open.audit.mn](http://open.audit.mn) цахим хаягуудаар болон уг QR кодыг уншуулан дэлгэрэнгүй тайлантай танилцана уу.

Мэйл хаяг: [uvurkhangai@audit.gov.mn](mailto:uvurkhangai@audit.gov.mn)

Аудитын харилцан хамаарал: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, аудитын дэд төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ: Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх,
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж хугацаанд гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх

Аудитаар Өвөрхангай аймагт 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн аймгийн ЗДТГ болон СТСХ, ХБТХОХ, ГХБХБГ, ОНӨГ, ХААГ, Арвайхээр, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Уянга, Тарагт, Зүүнбаян-Улаан, Хужирт, Хархорин, Есөнзүйл зэрэг сумдыг хамруулж, талбар дээр ажилласан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан, баримт материалыг үзэж нотлох баримтаа цуглуулсан.

**Аудитын дүн:** Аудитаар нийт **35,621.7** сая төгрөгийн зөрчил илэрч **8** албан шаардлага, **4** зөвлөмж, **8,001.9** сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцов.

## **1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт нь холбогдох хууль, журамд нийцээгүй байна**

**Төсөл арга хэмжээний ихэнхийг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн байна.**

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Өвөрхангай аймагт 458,098.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 143,923.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 75 төсөл арга хэмжээ батлагджээ. Үүнээс 230,455.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжиж ирсэн байна.

Өвөрхангай аймагт 2024 онд шинээр хэрэгжиж эхэлсэн 227,643.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 88,436.1 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 37 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 98,626.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 33 төсөл, арга хэмжээ нь дараах урт болон дунд бодлогын бичиг баримттай уялдсан байна.

- Алсын хараа-2050,
- Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”,
- Монгол Улсын “2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”

Эдгээр 22 төсөл, арга хэмжээг Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлого, Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөжээ.

Харин аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаагүй 45,672.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээ төлөвлөсөн байна.

**Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөөгүй, аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй байна.**

Өвөрхангай аймгийн Засаг дарга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 58 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлэн мэдээллийг хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулж, жагсаалтыг албан бичгээр холбогдох яаманд хүргүүлсэн байна.

Эдгээр 58 саналаас 26 нь Монгол улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн хавсралтад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан байна.

Харин 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрх шилжиж ирсэн 19,747.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 7,002.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл арга хэмжээг аймгийн ТЭЗ-ийн саналд үндэслээгүй баталжээ.

Хууль тогтоох эрх бүхий байгууллага нь дээрх 7 төсөл, арга хэмжээг батлахдаа хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй байна. Иймд эдгээр төслүүд хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэх эсэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг үр нөлөөтэй эсэх зэргийг нотлох боломжгүй байна.

ХБТХОХ-ээс Сангийн яамны <https://pimis.mn> цахим системд оруулсан 58 төсөл, арга хэмжээг маягтын дагуу боловсруулсан боловч зарим төсөл, арга хэмжээг нийгмийн ач холбогдлоор нь тооцож, үнэлж, эрэмбэлэх дараах шаардлагыг хангаагүй байна.

- Холбогдох тооцоолол, дэлгэрэнгүй мэдээлэл, нотлох баримт бичгүүдийг цахим системийн холбогдох цэсүүдэд оруулаагүй,
- Мэдээллийн бүрэн, үнэн зөв байдал, иж бүрдлийг хангаагүй,
- Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл явц, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын тооцоолол бодит бус байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29<sup>1</sup> дүгээр зүйлийн 29<sup>1</sup>.1 дэх заалт<sup>1</sup>, Сангийн сайдын 2018 оны 295 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө

оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын 3.8<sup>2</sup>, 3.9<sup>3</sup> дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3.1.1<sup>4</sup>, 2.3.1.3<sup>5</sup> дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### **Төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахдаа Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлтэй нийцүүлээгүй байна**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд эрх шилжүүлсэн 33 төсөл арга хэмжээнээс 32,663.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээг төлөвлөлтийн шаардлага хангаагүй, зураг төсөвгүйгээр батласан байна.

19 төсөл арга хэмжээ нь улсын төсөв батлагдсанаас хойш зураг төсөв боловсруулж, магадлалаар баталгаажуулах ажлыг зохион байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>2</sup> дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3<sup>6</sup>, 13.3.3<sup>7</sup>-д заалттай нийцэхгүй байна.

### **Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр 229,450.7 сая төгрөгийн өртөг бүхий 38 төсөл арга хэмжээг тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой байдлаар төлөвлөсөн байна.

## **2. Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТ-ыг зөрчсөн байна**

### **Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан ч тендер зарлах хугацааг мөрдөж ажиллаагүй байна**

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2023 оны А/757 дугаар тушаалаар 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталжээ. Төлөвлөгөөнд улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих 98,626.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй эрх шилжиж ирсэн 33 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар төлөвлөж, зохион байгуулсан байна.

Төлөвлөгөөгөөр дээрх 33 төсөл арга хэмжээг 2024 оны 1 дүгээр сард 18, 2 дугаар сард 5, 3 дугаар сард 6, 4 дүгээр сард 2 төсөл арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн ч 30 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд нь зохион байгуулаагүй, 10-157 хоногоор хэтрүүлсэн нь тендерийн захиалгыг ХБТХОХ-ээс ирүүлсэн тухай бүрд зохион байгуулсантай холбоотой байна.

<sup>1</sup> 29<sup>1</sup>. 1. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна.

<sup>2</sup> 3.8 Энэхүү журам, аргачлалын дагуу Аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төслийн саналыг тооцоо судалгаанд үндэслэн холбогдох аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэн сонгосны үндсэн дээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

<sup>3</sup> 3.9 Энэхүү журам болон холбогдох аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэхэд холбогдох тооцоолол, үндэслэл, дэлгэрэнгүй мэдээлэл, нотлох баримт бичгүүдийг Цахим системийн холбогдох цэсүүдэд оруулж, мэдээллийг бүрэн, үнэн зөв байдал, иж бүрдлийг хангасан байна.

<sup>4</sup> тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх;

<sup>5</sup> төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

<sup>6</sup> Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:

<sup>7</sup> техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

Тендерийг нээх, гэрээ байгуулахад хууль журамд заасан хугацааг мөрдөж ажилласан тул худалдан авах ажиллагаа зохион байгуулсан хугацаанаас шалтгаалж төсөл, арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон нөхцөл байдал үүсээгүй байна.

Харин ХБТХОХ-ээс багцын ажлын тоо хэмжээ бүрэн бус ирүүлсэн байхад худалдан авах ажиллагааг түтгэлзүүлээгүй, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.17<sup>8</sup>-дэх хэсгийг зөрчин тендер зарлаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 25,701.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь магадлалын дүгнэлтээс бага дүнгээр батлагдсантай уялдуулан ХБТХОХ нь дотор засал, гадна тохижилт, гадна шугам сүлжээ, гадна цахилгаан, холбоо дохиолол, буулгалтын ажлыг хасаж Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн байна. Гэтэл тус газар нь хасаж ирүүлсэн ажлын тоо хэмжээг хянаж үзэхгүйгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

### **Тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулсан боловч зарим алдаа дутагдал гарч байна**

Өвөрхангай аймагт эрх шилжсэн 33 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог тухай бүр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг хууль, журам, жишиг баримт бичгийн дагуу, захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Үнэлгээний хорооны шийдвэрийг гишүүдийн 85-аас багагүй хувийн ирцтэйгээр гаргасан ба хүчин төгөлдөр бус шийдвэр гараагүй байна. Тендерийн баримт бичгийг тендерийн жишиг баримт бичгийг үндэслэн ерөнхий шаардлагыг тавьж, ХБТХОХ-ээс ирүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу боловсруулсан байна.

Гэвч тендерийн баримт бичгийн боловсруулалтад зарим алдаа дутагдал гарсаар байна.

Тендерийн баримт бичгийг батлах явцад хугацааны болон бичилтийн алдаа гаргах зөрчил түгээмэл байна.

### **Үнэлгээний хороо нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна**

Тендерийг зарлахдаа тендерийн урилга, холбогдох баримтыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайтаар нээлттэй мэдээлж, тендерийн үйл ажиллагааг 100.0 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, оролцогч болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товчлон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

Тайлант онд эрх шилжиж ирсэн 98,626.1 сая төгрөгийн 33 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, тендерт шалгарсан оролцогч нартай 96,646.8 сая төгрөгөөр төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулснаар төсөвт 1,979.8 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан байна.

<sup>8</sup> Хуулийн 45.2-т заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгаврыг ирүүлээгүй, илтэд алдаатай, эсхүл бүрэн бус ирүүлсэн бол мэргэжлийн байгууллага ажлын гурван өдрийн дотор захиалагчид мэдэгдэж, төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг холбогдох баримт бичиг бүрэн ирүүлэх хүртэл хугацаагаар зарлахыг түдгэлзүүлнэ.

Харин 15,108.2 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийг 26.4<sup>9</sup>, 26.4.1<sup>10</sup>, 50.10<sup>11</sup> дах заалтуудтай нийцэхгүй байна.

**3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу бүрэн санхүүжүүлсэн боловч зарим ажлын чанар, гүйцэтгэл хангалтгүй, хөрөнгийг бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.**

**Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон байна.**

Өвөрхангай аймгийн Засаг даргад эрх шилжсэн өмнөх оны 28, тайлант оны 31, нийт 59 төсөл, арга хэмжээнд 61,849.9 сая төгрөгийг төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 52,638.0 сая төгрөгийн санхүүжилт олгож, 9,211.9 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд үлдээж, 2 төсөл, арга хэмжээний 1,151.2 сая төгрөгийн санхүүжих боломжийг алдсан байна.

Харин улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 2 төсөл, арга хэмжээний 1,151.2 сая төгрөгийн санхүүжилтийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нийт төсөл, арга хэмжээний 85.2 хувийг төлөвлөсөн хугацаандаа хэрэгжүүлсэн байна**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд санхүүжүүлэхээр баталсан 61,849.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 59 төсөл, арга хэмжээний 54 нь барилга байгууламж, 5 нь тоног төхөөрөмж нийлүүлэх ажил байна. Үүнээс 18 барилга байгууламж, 5 тоног төхөөрөмжийн ажлыг төлөвлөсөн хугацаанд нь хэрэгжүүлж, гэрээг дүгнүүлсэн байна.

Харин 2024 онд шинээр хэрэгжүүлж эхлэхээр хуульд тусгагдсан 3 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж эхлээгүй байна. Мөн өмнөх онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн боловч хэрэгжиж дуусаагүй 5 төсөл арга хэмжээ байна.

Барилгын ажил гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хугацаа, захиалагч талаас гаргах шийдвэр, хүлээлгэх хариуцлагатай холбоотой нарийвчилсан зохицуулалт хангалтгүй, гэрээг сунгах шалгуур, эрх зүйн зохицуулалт тодорхой бус байна.

**Хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа зарим барилга угсралтын ажлыг зураг төсвийн дагуу хэрэгжүүлээгүй, гүйцэтгэлийн чанар хангалтгүй байна**

Зарим төсөл арга хэмжээний зураг төсөл зохиогч хууль тогтоомжид заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжиж байгаа болон өмнөх онуудаас шилжих барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, авто замыг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг барилгын ажлын талбар дээр очиж үзэхэд зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн чанар хангалттай байна.

Аймгийн ГХБХБГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа инженерүүд талбайн журналыг бүрэн хөтлөөгүй, үүрэг даалгаврын биелэлтийг дэвтэрт бичиж, үйлдээгүй,

<sup>9</sup> 26.4. Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ:

<sup>10</sup> 26.4.1 энэ хуулийн 15, 16, 17 дугаар зүйлд заасан чадаахын болон туршлагын доод шаардлагыг хангасан байх;

<sup>11</sup> 50.10. Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлон, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

гэрээний хугацаанд тавих хяналт хангалтгүй, гүйцэтгэгч барилгын ажлыг чанаргүй гүйцэтгэх зөрчил давтагдан гарсаар л байна.

Өмнөх аудитаар өгсөн 8 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг, төсвийн дагуу гүйцэтгэх хугацаатай албан шаардлагын хэрэгжилтийг үзэхэд хангалтгүй байна.

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа ихэнх барилгыг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаагүй байна.**

Өвөрхангай аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх талаар аймгийн ИТХ-ын даргын 2024 оны А/77 тоот захирамж гарчээ. Тус захирамжийн дагуу ашиглалтад орсон 20,538.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 барилга байгууламж, 2,965.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төрлийн тоног төхөөрөмж, 9,474.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй байгууламж, автозамд эзэмшигч тогтоож, мөн 51,076.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл арга хэмжээг аймгийн ЗДТГ-ын дуусаагүй барилга байгууламжид бүртгэх шийдвэр гарч нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Улсын комисс хүлээлцсэн актыг үндэслэн ашиглалтад орсон 14 төсөл, арга хэмжээг бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж байна. Харин аймгийн ЗДТГ-ын дуусаагүй барилга байгууламж дансанд дараах 21 төсөл арга хэмжээг бүртгэхдээ 3,015.3 сая төгрөгөөр дутуу, 2 төсөл арга хэмжээг 1,479.1 сая төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил илрэв.

Мөн 5,352.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилгын эзэмшигч тогтоож, бүртгэх шийдвэр гараагүй, аймгийн ИТХ-ын даргын захирамжаар эзэмшигч тогтоосон боловч эзэмшигч нь нягтлан бодох бүртгэлд тусгаагүй зөрчлүүд байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа 6,191.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 барилгын гүйцэтгэл 90.0-95.0 хувьтай байна. Барилгыг байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаагүй, барилга ашиглах шийдвэр гаргаагүй байхад ашиглагч байгууллагууд болох Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Тарагт сумын ЗДТГ нь үйл ажиллагаагаа явуулж байна.

## **ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

### **АУДИТЫН ДҮГНЭЛТ:**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлт хийж байна.**

Үүнд:

1. Төсвийн тухай хуулийг зөрчин зураг төсөл нь хийгдээгүй, магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээг баталснаас төсвийн ачаалал нэмэгдэх, хэрэгжүүлэх үе шатад хүндрэл учрах эрсдэл үүсэж байна.
2. Өвөрхангай аймгийн Засаг даргад эрх шилжсэн 33 төсөл, арга хэмжээнээс 2 нь гүйцэтгэгч ажлаа эхлүүлээгүй, дутуу хийснээс шалтгаалан 1,152.1 сая төгрөгийн санхүүжих боломжийг алдсан байна.
3. Үнэлгээний хороо нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.
4. Төсөл арга, хэмжээнд хууль тогтоомжийн дагуу захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч гүйцэтгэгчийн гаргасан зөрчил дутагдалд хариуцлага тооцохгүй байгаагаас ажлыг чанаргүй хийх байдал давтагдан гарч байна.
5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаагүй

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

### **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.ПҮРЭВДОРЖ**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, зардал үр дүнгийн шинжилгээний тооцооллыг хийж, эрэмбэлэн хууль журамд нийцүүлэн төлөвлөж байх;
2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацааг мөрдөж ажиллаж байх,
3. Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147, 211 дүгээр тушаалаар батлагдсан журмуудыг мөрдөж ажиллаж байх,
4. Барилга байгууламжийн зураг төслийг холбогдох хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу боловсруулаагүй Зэдпроект ХХК, Инж байгууламж ХХК-тай гэрээг дүгнэж, хариуцлага тооцох, Барилгын тухай хуулийн 23.2<sup>12</sup>-т, Засгийн газрын 2019 оны 108<sup>13</sup> дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан дүрмийг мөрдөж ажлуулах, аймгийн ерөнхий архитектор нь боловсруулсан зураг төслийг гэрээт зохиогчоос ажлын даалгаврын дагуу хүлээн авч байх,

### **Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газарт хүргүүлэх санал**

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ТЭЗ-аас ирүүлсэн саналыг үндэслэн хуульд өргөн барьж байх зөвлөмжийг холбогдох яамдад хүргүүлэх.
2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>14</sup> дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.3<sup>15</sup>-д заалтуудыг зөрчих байдал арилахгүй байгаа тул зөрчлийг арилгах зөвлөмжийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх.

<sup>12</sup> 23.2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу баталгаажуулсан барилга байгууламжийн байршил, загвар зураг, техникийн нөхцөлүүдэд үндэслэн эх загвар зураг /эскиз/, иж бүрэн ажлын зураг төслийг боловсруулна.

<sup>13</sup> Засгийн газрын 2019 оны 108 тогтоол Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм

<sup>14</sup> 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>15</sup> 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.